

Хавцал

Хотод гарсан нэгэн газар хөдлөлтийн улмаас хотын газар голоороо 2 хэсэгт хуваагдсан байна. Тэгээд хотын инженерүүд 2 хуваагдсан газрыг 2 талаас шахаж нийлүүлж болох талаар мэдээллэсэн бөгөөд ингэхийн тулд эхлээд хуваагдсан 2 талыг шахахад яг таг нийлж чадаж байгаа эсэхийг эхлээд мэдэх хэрэгтэй болжээ. Тиймээс хотын нэр хүнд бүхий програмист болох танаас хотын иргэд энэ мэдээллийг боддог программ бичиж өгөхийг хүсчээ.

Газрыг x , y тэнхлэгт байгаа гэж үзэх ба газар хөндлөгөөрөө хагарсан. Өөрөөр хэлбэл хагарлын үр дүнд газар дээр доор гэсэн 2 эх газарт хуваагдсан. Мөн дунд нь ямар ч арал үүсээгүй бөгөөд хуваагдсан газрууд дунд нүх үүсээгүй болно.

Input

Оролтын эхний мөрөнд тестийн тоо болох T ($T \leq 100$) тоо өгөгдөнө. Дараагийн мөр хоосон байна. Тэрний дараагийн мөрөөс тестүүд хоорондоо хоосон мөр үлдээлгүйгээр өгөгдөнө. Тест бүрийн эхний мөрөнд баганын тоо болох W . Дараагийн W мөр бүр нэг баганыг илэрхийлэх болно. Хамгийн эхний мөр хамгийн зүүн талд байрлаж байгаа баганыг, дараагийн мөр тэрний баруун талын баганыг харин W дахь мөр хамгийн баруун талд байрлаж байгаа баганыг илэрхийлэх болно. Мөр бүрд 2 тоо байх ба эхний тоо y_1 нь хавцлын хамгийн дээд талын мөрийг, дараагийн тоо y_2 нь хавцлын хамгийн доод талын мөрийг илэрхийлнэ. ($-100 \leq x, y \leq 100$) бүхэл тоо.

Output

Дараалсан 2 тестийн хариу бүр хоорондоо хоосон мөрөөр тусгаарлагдана. Хэрвээ 2 эх газарийг нийлүүлэхэд ямар ч хавцал үлдэхгүйгээр яг нийлж байвал yes үгүй бол no гэсэн хариуг тест бүрт хэвлэ.

Example

Input:

```
1
5
2 1
0 -1
1 0
1 0
2 1
```

Output:

```
yes
```